



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/226

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх,  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйл, Мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 17-24 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тэнүүн байгаль" ХХК-ийн үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх /814А ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд/, "Шинь шинь" ХХК-ийн үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх /MV-000247 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд/, "Доншен газрын тос (Монгол)" ХХК-ийн газрын тосны чичирхийллийн хайгуулын тэсрэх материал импортлох, тэсэлгээний ажил хийх тусгай зөвшөөрлийг 3 /гурван/ сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Хавсралтад заасан үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.


3. "Тэнүүн байгаль" ХХК, "Шинь шинь" ХХК, "Доншен газрын тос (Монгол)" ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон аж ахуйн нэгж, байгууллагуудад болон холбогдох төрийн байгууллагуудад мэдэгдэл хүргүүлж, мэдээллийг мэдээллийн санд бүртгэхийг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Даваадорж/-т даалгасугай.

САЙД  Д.СУМЪЯАБАЗАР



08 0632

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн  
А/166 дугаар тушаалын хавсралт



Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаагүй хууль зөрчсөн аж ахуйн нэгжүүд

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Тусгай зөвшөөрлийн төрөл	Олгосон огноо, дугаар
1	"Орика Монголиа" ХХК	үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэрх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах	2015.04.27 № 155
2	"СС Монголиа" ХХК	үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх /MV-001071 ашиглалтын тусгай зөвшөөрөлийн талбайд/	2017.01.03 № 22
3	"Цайрт минерал" ХХК	үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэрх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх	2015.02.17 № 137
4	"Дун юань" ХХК	үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх /985А, 15032А, 15033А ашиглалтын тусгай зөвшөөрөлийн талбайд/	2014.02.20 №48 /хугацаа дууссан/
5	"Балапан девелопмент" ХХК	үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх	2014.04.21 № 68 /хугацаа дууссан/
6	"Хөх жонш" ХХК	үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх /MV-016968 ашиглалтын тусгай зөвшөөрөлийн талбайд/	2014.09.22 № 117 /хугацаа дууссан/
7	"Фокус металл майнинг" ХХК	үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх /MV-012263 ашиглалтын тусгай зөвшөөрөлийн талбайд/	2014.09.16 /хугацаа дууссан/
8	"Хэт" ХХК	газрын тосны чичирхийллийн хайгуулын тэсрэх материал импортлох, тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх	2015.04.01 № 146